

Сэдэв: Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих нь

Илтгэгч: Суваанкар овогтой Сарангарав

Цэрэннадмид овогтой Наранжаргал

Цэцэрлэг: Улсын тэргүүний 61 дүгээр цэцэрлэг

Харилцах утас: 98107888; 88284161

И-мэйл хаяг: sarangarav81@yahoo.com

Naraajargal888@gmail.com

Гарчиг

Удиртгал

Нэгдүгээр бүлэг.

Багшийн хөгжлийн онол арга зүйн зарим асуудал

1.1. Багшийн хөгжил

1.2. Багш ажлын байранд суралцах хэлбэр

1.3. Сургуулийн өмнөх боловсролын багшийн хөгжлийн өнөөгийн байдал

Хоёрдугаар бүлэг.

Сургуулийн өмнөх боловсролын багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих нь

2.1. Судалгааны арга зүй, аргачлал

2.2. Судалгааны ажлын үр дүн

Дүгнэлт

Ном зүй

Оршил

Улс орны нийгэм эдийн засаг, соёлын үнэт зүйлсийн хөдөлгөгч хүч нь боловсролын хөгжил байдаг. Боловсролын хөгжил нь өөрчлөлтийн үр дүнд шинэчлэгдэн урагшилж байдаг тасралтгүй үйл явц юм.

Монголын боловсролын чиг хандлагын өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч болсон багш түүний хөгжлийн тухай ойлголт, тулгамдсан асуудалыг шийдвэрлэх арга зам, үр дүнгийн шалгуур үзүүлэлт зэргийг авч үзэх шаардлага багш бидний өдөр тутамын ажлаас урган гардаг асуудлын нэг билээ. Өндөр хөгжилтэй орнуудын тэр дундаа боловсролын шинэчлэл хийгдэж байгаа орнуудад багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт нь хуримтлуулсан туршлага мэдлэгээ шинэ шаардлагатай нийцүүлэн хөрвөх чадвар эзэмшүүлэх бие биеэсээ харилцан суралцуулах боломж олгох, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл явц болж байна.

Багшийн хөгжлийн асуудлыг багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх гэсэн 2 шаттайгаар шийдвэрлэж ирсэн боловч багшийн хөгжил бол нэг талаас төрийн зүгээс багшийг хөгжүүлэх бодлого дэмжлэг нөгөө талаас багшийн өөрийн хичээл зүтгэл гэсэн хоёр хүчин зүйлийн зангилаа юм. Орчин цагийн нийгмийн хөгжлийн хурд асар хурдтай хөгжиж байгаагийн зэрэгцээ багш хэмээх ирээдүйн эзэдийг бэлтгэгч гол хөшүүрэг нь тухайн нийгмийн хурдтай хөл нийлүүлэн алхах нь улс орны хөгжилд тулгуур болох нь дамжиггүй. Энэ толгой эргэм хурд нь хүнийг ажилдаа, мэргэшсэн газартаа өөрийгөө хурдан өөрчлөх хэрэгтэйг харуулж байна.

Удиртгал

Сэдэв судлах болсон үндэслэл

Нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь боловсрол, боловсролын хөгжлийн цөм нь багшийн хөгжил гэж үздэг. Иймээс багш нар мэдлэг боловсролоо дээшлүүлж, хөгжихийн тулд өөрсдөө идэвхи санаачлага гаргах, мэргэжил дээшлүүлэх арга хэрэгсэл хэлбэрийг оновчтой сонгох, ажиллах явцдаа ажлын байрандаа мэдлэг боловсролоо дээшлүүлж, тасралтгүй суралцагч байх шаардлагатай тул сонгож авлаа.

Түлхүүр үг: Хөгжих хэрэгцээ¹, Цахим хуудас², Төлөвлөгөө³, Багш боловсрол⁴

Судалгааны зорилго

Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжиж байгаа байдлыг судлах

Судалгааны зорилт

1. Багшийн хөгжлийн холбогдолтой онолын материалыг судлах
2. Ажлын байрандаа тасралтгүй хөгжиж байгааг судалж, үр дүнг тооцох
3. Ажлын байранд тасралтгүй хөгжихөд тулгарч буй бэрхшээл, тэдгээрийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тодруулах

Судалгааны объект

СӨБ-ын багш нарын ажлын байранд тасралтгүй хөгжих үйл явц

Судлах зүйл

СӨБ-ын багшийн ажлын байранд тасралтгүй хөгжих нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Судалгааны практик ач холбогдол

СӨБ-ын багшийг ажлын байрандаа тасралтгүй хөгжиж байгааг судлан боломжит хувилбаруудыг илрүүлэн тогтоосон судалгааг багш нар өөрийгөө хөгжүүлэх ажилдаа авч хэрэглэх нөхцөлийг олгож байгаа юм.

Судалгааны хамрах хүрээ

Баянзүрх дүүргийн Улсын тэргүүний 61-р цэцэрлэгийн 15 багш, online хэлбэрээр судалгаанд оролцогчид / СӨББ-ын/

Судалгааны шинэлэг тал

Багш ажлын байрандаа тасралтгүй хэрхэн хөгжиж байгааг ажлын байранд нь бичгээр, online хэлбэрээр гэсэн хоёр өөр аргаар цэцэрлэгийн багш нараас авч харьцуулсан судалгаа гаргаж үзсэнээрээ шинэлэг талтай.

Судалгааны арга

1. Эх зохиол судлах арга
2. Ажиглалтын арга
3. Ярилцлагын арга
4. Санал асуулгын арга
5. Математик боловсруулалтын арга

¹ Хөгжих хэрэгцээ - Хөгжихөд шаардагдаж буй гачигдал

² Цахим интернет тэмдэглэл буюу вэб сайтын нэгэн төрөл

³ Төлөвлөгөө - Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд өөртөө зориулсан өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах нь амжилтанд хүрэх гол чиглэл.

⁴ Багш боловсрол- Багшлахад хэрэглэгдэх чадваржсан мэдлэг

Нэгдүгээр бүлэг. Багшийн хөгжлийн онол арга зүйн зарим асуудал

1.1 Багшийн хөгжил

Тогтвортой хөгжлийн үндэс нь багш бүр өөрийн хөгжлийг хангах явдал юм. Иймээс үйл ажиллагааныхаа явцад өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж улмаар хөгжлийн хурдацаас хохрохгүй байх чадварыг багш бүрээс шаардагдаж байна.

Багш бол хүүхэд залуусыг хөгжүүлэн төлөвшүүлэх, нийгэмшүүлэх үүргээ биелүүлэхийн тулд тасралтгүй хөгжиж байх, өөрийнхөө олон талын мэдлэг чадвараа үргэлж дээшлүүлж боловсронгуй болгох нь чухал юм. Хөгжлийн асуудлыг ярихын тулд хөгжил гэсэн үгийн утгыг ойлгох зүй.

Хөгжил гэдэг нь өмнө байсан мэдлэг, чадвар дээрээ суурилсан шинэ мэдлэг, шинэ чадвар өөртөө олж авахыг хэлнэ. Гэвч үйл ажиллагаа бүрээс шинэ санаа, шинэ агуулга ойлголтуудыг эзэмших боломжгүй үе ч бий. Ийм нөхцөлд мэдлэгийн хүрээгээ тэлж, түүнийгээ хэрэглээ болгож сурах нь үр дүнтэй. Үүнээс үзэхэд хөгжил нь хүний хандлага, төлөвшилд нь чанарын өөрчлөлт гарах үзэгдэл бөгөөд өөрийн дотоод хүч санаа бодолыг хөгжүүлэхгүйгээр түүний хөгжлийн тухай яриад ч илүүц буй за.

Хүн өөрийнхөө хөгжлийг хангахын тулд зайлшгүй шаардлагатай онолын үзэл баримтлалуудыг ойлгож мэдэх нь чухал. Үүнд:

Багш түүний хөгжлийн талаарх үзэл баримтлал нь дараах үндсэн чиглэлүүдтэй байдаг.[1:90]

Бүдүүвч №1

- Багшийн хөгжлийг сургахуйд сургах үйл явц талаас нь авч үздэг. Сурах үйл ажиллагааны бихеворизмийн онолд тулгуурладаг энэхүү үзэл баримтлал нь удирдлагын дээд түвшнээс мэргэжил дээшлүүлэх сургалтаар багшийг хөгжүүлнэ гэж үздэг.

Техникийн үзэл баримтлал



- Гол зорилго нь хөтөлбөрийг мэргэжлийн талаас бүрэн ухаарч, сургах эв дүй болгон хөгжүүлэх.

- Багш бол шинжээч тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэгч гэж үздэг. Багш шавийнхаа болон өөрийнхөө үйл ажиллагаанд тохиолдож байгаа хүндрэл бэрхшээлийн шалтгааныг шинжлэн судлах замаар илрүүлж, засан сайжруулах арга замыг хайх явцдаа хөгждөг.

Шинжээчийн үзэл баримтлал

- СХУ-ны итгэл үнэмшлийн болон туршлагын өвөрмөц экологийн тогтолцоог илэрхийлэгч гэсэн санаанд үндэслэн гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, багшийн хөгжил нь аяндаа явагдах үйл явц биш, сургуулийн өдөр тутамын амьдралд тасралтгүй үргэлжлэх, суралцах явцын үр дүн юм.

Экологийн үзэл баримтлал



- Энэхүү үзэл баримтлал нь сурах үйл ажиллагааны конструктивизмын онолд тулгуурлана.

Багшийн хөгжлийн онолын үзэл баримтлалд дараах үндэслэлийн өөрчлөлт орж байна. Багшийн хөгжил нь боловсролын салбарын өөрчлөлт түүний үр дүн болсон шинэчлэлийг араасаа дагуулж байдаг. Онолын үүднээс авч үзвэл:

Багшийн хөгжлийн онол үзэл баримтлал

Бүдүүвч №2



Сэтгэл судлаач А.Адлерийн “Хүн бол мөн чанарын хувьд сөрөгөөс эерэгрүү төгс бусаас төгсрүү дэгжин дээшлэх гэсэн аугаа их хэрэгцээг илтгэж байдаг”. Тийм учраас багшийн хөгжил бие сэтгэхүйн болоод бүтээлч үйлээр тасралтгүй явагдах ахиц дэвшил байх ёстой. Багш нь өөрөө өөрийнхөө өмнө хариуцлага хүлээдэг, тодорхой зорилготой түүндээ хүрэх чин эрмэлзэлтэй өөрийн хүч бололцоотой зөв мэдэрч залах боломжтой өөрөө хөгжих явц гэж бодож байна. Багшийн хөгжил гэдэг нь: хувь багш өөрийгөө өөрчлөх бүхий л боломжийг агшиглан мэргэжил, мэргэшил боловсролоо байнга дээшлүүлж, цаг ямагт өсөж хөгжиж байдаг идэвхитэй хандлага үйл явц юм. [10:9]

Боловсролын салбарын үр агшигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц нь өндөр мэдлэг чадвартай багш бөгөөд тасралтгүй өөрчлөгдөн хөгжиж байхыг шаардаж байна. Иймээс багшийг хөгжлийн хүрээг авч үзье.

Багшийг хөгжлийнх нь хүрээгээр:

- Хөгжих бололцоотой болсон багш
- Хөгжиж буй багш
- Хөгжсөн багш хэмээн ангилж болох юм. [10:6]

Хөгжих бололцоотой болсон багш гэдэг нь багш бэлтгэдэг сургуулийг бакалаврын боловсролын зэрэгтэй төгссөн, анхны жилүүддээ багшилж багш юм.

Хөгжиж буй багш гэдэг нь тухайн шинжлэх ухаан болон түүний дидактикийн онол, арга зүйг гүнзгийрүүлэн судалж, мэргэшиж байгаа, ур чадвараа системтэй дээшлүүлэн,

өөрийгөө боловсруулан хөгжүүлэх тодорхой зорилго, чиглэлтэй ажиллаж буй багшийг хэлнэ.

Хөгжсөн багшийн тоонд хэнийг оруулах нь харьцангуй асуудал бөгөөд мэргэжил, мэдлэг, ур чадвараараа төгс мэргэшсэн, нийгэмшил төлөвшилийн өндөр түвшинд хүрсэн, судалгаа, шинжилгээний ажлын арга барил судлал, арга зүйг сайн эзэмшсэн, энэ чиглэлээрээ бусдад орчин үеийн шаардлагад нийцсэн онол арга зүйн зөвөлгөө, мэдээлэл өгч чадах, цаашид улам хөгжин мэрэгших түвшинд хүрсэн багшийг оруулан авч болох талтай. Хөгжсөн багшийн загварыг дараахь байдлаар томъёолж, багш бүр энэхүү загварт хүрэхийг зорьж болох юм.

1. Төлөвшил хувийн шинжийн хувьд:

- Бие хүний ерөнхий шинж төлөвшсөн байх
- Өөртөө итгэлтэй
- Даяаршил, бүс нутгийн хөгжлийн хандлагыг мэдэрдэг
- Хуулбарлах иррационал бус, танин мэдэх рациональ хандлагыг ухаардаг
- Ур ухааныг төлөвшүүлэх прагматик чиглэлийг баримжаалсан
- Хүмүүнлэгийн болон социаль шинжийг эзэмшсэн
- Харилцааны сэтгэл зүй эзэмшсэн

2. Арга зүй, эв дүйн хувьд:

- Ерөнхий ба тусгай дидактикийн үндсийг мэддэг
- Гадаад хэлний бэлтгэлтэй
- Төлөвлөх баримжаалах чадвартай
- Хамтран ажиллах чадвартай
- Хүн хэрхэн суралцдаг зүй тогтолыг мэддэг, сургалтандаа ашигладаг
- Компьютерийн мэдлэг чадвартай
- Бие хүн хамт олныг судлах арга зүйг эзэмшсэн
- Суралцагчийг үнэлэх, хөгжүүлэх чадвартай
- Хөтөлбөр сурах бичгээ боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөх чадвартай
- Мэдээлэл олж авах, боловсруулах, солилцох, түгээх чадвартай
- Судалгааны арга, арга зүй эзэмшсэн
- Гадаад орчны өөрчлөлтөд зохицон хөрвөх чадвартай
- Зохион байгуулах чадвартай

3. Бүтээлч хандлагын хувьд:

- Шинэчлэгдэх чадвар
- Асуудлыг олон талаас нь иж бүрэн авч үзэх чадвар
- Олон хувилбараар сэтгэх чадвар
- Шийдвэр гаргах чадвар
- Өөрийгөө хөгжүүлэх чадвар
- Байнга суралцах чадвар
- Сургалт судалгааг хослуулах чадвар
- Орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар

4. Дидактик чадварын хувьд


- Онолын мэдлэгээ сургалтанд хэрэглэх чадвар
- Судалгааны арга зүй эзэмшсэн байх

- Хүүхдийн үйл ажиллагааг оношлох чадвар
- Бүлгийн хөгжлийн зүй тогтолыг мэдэж хэрэглэх чадвар
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх чадвар
- Үзэл бодолоо чөлөөтэй илэрхийлэх чадвар
- Хууль эрх зүйн мэдлэгтэй байх шаардлагуудыг хөгжсөн багшийн үнэт зүйл хэмээн үзнэ гэжээ.

Багш тасралтгүй хөгжих үйл явцын дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ итгэл үнэмшил, соёлын үнэт зүйл үйлдвэрлэгдэн тооны болон чанарын өөрчлөлт гарч байдаг. [13:36]

Багшийн хөгжил

Бүдүүвч №3



Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг багцлан сурах таатай боломж, сурах хүсэл тэмүүлэл гэсэн хоёр хүчин зүйлд багтааж болдог. Үүнд:

Сурах таатай боломж гэдэг нь багш хөгжих бололцоо, нөөцийн чадавх болон багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, шахаж шаардах боловсролын тогтолцоо бүтцийн болон хэмжээний хувьд хэрхэн уян хатан нээлттэй бүрэлдэн тогтсон байдал хоёрыг багтаан ойлгож болно. Бид энэ боломжийг хэт төвлөрсөн сургалтаар эдэлж байна.

Сурах хүсэл тэмүүлэл гэдэгт багш байнг мэдэрч, үргэлж сонирхолыг нь татаж байдаг, хөгжихийн хэрээр тансаг амьдарч ажиллах нөхцөл бүрддэг байх \Сэтгэл санааны болон материаллаг урамшуулал, шагнал, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх нээлттэй ил тод тогтолцоо, түүний үйл ажиллагааг ойлгож болно.

Багш нараа хөгжүүлэх боломж байгаа ч түүнийг яаж? Хэрхэн? Хэзээ? Хаана? Ямар багш нарыг ямар аргаар гэсэн асуултуудад багш нартайгаа ил тод санаа бодлыг нь сонсож, тулгамдаж байгаа асуудлыг ярилцах замаар дэмжлэг үзүүлж, шийдвэрлэх нь дутагдалтай байдаг. Манай орны багшийг хөгжүүлэх тэдний мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын тогтолцоо дараах бүтэцтэй байна.[6:103]

Багш хөгжүүлэх сургалтын тогтолцоо

Бүдүүвч №4



Багш нарын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, сургалт нь багшийг болон удирдлагыг хөгжүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

Өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй. Үүнд:

1. Цаг үе нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийг соргогоор мэдрэх
2. Сэтгэл судлал, сургах хүмүүжүүлэх ухаанд ямар нэг шинэ зүйл өөрчлөлт гарч байгааг мэдэрч тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэрэгтэйг олж авах, өөрийнхөө үйл ажиллагаанд эдгээрээс хэрэгтэйг нь тусгах
3. Хүүхдийг сайн ажиглах
4. Багш өөрийнхөө хэлсэн үг хийж буй ажлынхаа үр нөлөө, үр дагаварыг урьдчилан тооцоолж мэдрэх мэдрэмжтэй байх

5. Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх ажилдаа хандах хандлага, харилцаа зэргээ өөрчилж байх
6. Багш сурган хүмүүжүүлэх арга барил, ур чадвар, эв дүй, техник, технологио шинэчлэн, боловсронгуй болгох
7. Багш өөрийнхөө сурган хүмүүжүүлэх ёс зүйн төлөвшил, харилцаанд анхаарч ажиллах
8. Сурган хүмүүжүүлэх ажлаа оновчтой зохион байгуулах, цагийг үр өгөөжтэй ашиглах, өдөр бүр өөрийгөө хөгжүүлэх 1-2 цаг гаргах
9. Бусад багш нар эцэг эхтэй хамтран ажиллах
10. Олон талын шинжлэх ухааны суурь мэдлэгтэй байх
11. Судалгааны ажлын арга барилыг эзэмших гэх мэт үйл ажиллагаагаар багш өөрийгөө хөгжүүлэх боломжтой.

1.2 Багш ажлын байранд суралцах хэлбэр

Ажлын байран дээр суралцах нь багшийг хөгжүүлэх сургалтын тасралтгүй байх нөхцөлийг хангадаг. Ажлын байран дээр суралцах нь өдөр тутамын үйл ажиллагааны нэг хэсэг болсон нөхцөлд багшийн хөгжил тасралтгүй явагдана.

Цэцэрлэг дээрээ суралцах нь хувь багш, бүлэг, цэцэрлэг аль алиныг нь хөгжүүлдэг ач холбогдолтой. Дор дурьдсан дэвшилтэт оролцооны аргыг бүх шатны байгууллагуудад ашиглах боломжтой.

Үүнд:

- Багаар ажиллах: Мэдлэг мэдээллээ хуваалцахыг үйл ажиллагааны хэвшил болгох. Багш нар мэдээллийг хүлээн авч чаддаг байхаас гадна түүнийг боловсруулах өөрийн болгож хэрэглэх, дамжуулах чадварыг эзэмших нь чухал. [11;29]
- Өдөр тутамын уулзалт: Хоёр хоёроор гэсэн зарчимаар ажиллаж, тулгарсан асуудалд хариу өгч, шийдэлд хүрэх замаар суралцан хөгжих
- Шийдвэрлэх асуудалд тулгуурлан суралцах: Багш нар мэдээлэл хайж олж авах, түүнийгээ хуваалцах, туршилт хийж, шийдэлд хүрэх ба төгсгөлд нь шинээр олсон зүйлийнхээ талаар бусаддаа мэдээлэх
- Шавилан суралцах: Илүү туршлагатай багш нь туршлага багатай нэгэндээ дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Суралцагчийн хөтөлбөр: Туршлагатай болох боломж олгохын тулд залуу багш нарыг тухайн цэцэрлэгийн янз бүрийн ангид хичээл заалгах, сурган, сэтгэлзүйн чиглэлээр ажиглалт хийлгэх.
- Мэргэжлийн хичээлүүдийг сэлгүүлэн заалгах
- Төслийн ажил: багшийн онцгой ур чадвар, ажлын туршлагад нь тулгуурлан тодорхой хугацааны дотор шинэ зүйлийг боловсруулах үүрэгтэй ажиллуулах. Багшийн хөгжлийн арга хэмжээнд төсөлт ажлыг ашигласнаар багшийг дахин мэрэгшүүлэх үйл ажиллагаанд хүч, нөөцөө хэмнэх, хамтран хөгжих, багшийн хөгжил, төлөвшилийн арга хэмжээний үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Багшийг хөгжүүлэхийн тулд дараах шаардлагыг хангасан байна.

- Багшийг хөгжүүлэх арга хэмжээ нь тэдний болон цэцэрлэгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Энэ үүднээс багшийг хөгжүүлэх арга хэмжээг тодорхойлохын өмнө хэрэгцээгээ үнэлсэн байна.
- Цаг хугацааны хүчин зүйлийг зөв харгалзаж, аль хэрэгцээтэй үед нь хөгжүүлэх арга хэмжээ авах нь илүү үр ашигтай байна. Цэцэрлэгийн удирдлага нь ирээдүйг харж багшийн хөгжлийн хэрэгцээг урьдчилан тодорхойлж, түүнийг төлөвлөнө.
- Багшийг хөгжүүлэх явдалыг үр ашиг, үр нөлөөтэй болгохын тулд бүх боломжит нөөцийг үр ашигтай ашиглана. Үүнд багшийн мэдлэг ур чадвар, туршлагыг оролцогчийнх нь хувьд, мөн тэднийг дотоодын сургагчаар ашиглаж болно. Багш бэлтгэдэг их дээд сургууль болон бусад байгууллагуудыг төрийн төрийн бус өмчийн ялгаа харгалзахгүйгээр багшийн хөгжлийн хэрэгцээг хангахад татан оролцуулж болно.
- Багшийг хөгжүүлэх үйлсэд багш бүрийг оролцуулахыг эрмэлзэх хэрэгтэй. Ийнхүү багшийг хөгжүүлэх үйлсэд тэднийг оролцуулах нь зардал хямдтай, практик үр дүн сайтай боломж гэж үзэж байгаа юм.
- Багшийн хөгжил нь урамшуулан дэмжихийг шаардаж байна. Багш нараас ажлын буюу ажлын бус цагаар өөрсдийгөө хөгжүүлэх явдлыг урамшуулан дэмжих үүднээс сэтгэл санааны болон эдийн засгийн урамшууллын аль алиныг нь хэрэглэж болно.

1.3 СӨБ-ын багшийн хөгжлийн өнөөгийн байдал

Багшийн хөгжлийн өнөөгийн байдлыг авч үзэхийн тулд зарим холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмаас авч үзлээ. Үүнд: Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд [9;5]

Боловсролын үйлчилгээг нийгэм соёлын үүсэн буй үнэт зүйлс, итгэл үнэмшил, хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх, боловсролын системийн бүтэц, тогтолцоо, сургалтын хөтөлбөр, агуулгыг улам боловсронгуй болгож дэлхийн хөгжингүй орнуудын нийтлэг жишигт хүргэх, хүний эзэмшсэн боловсрол нь эргээд өөрт нь цаашид тасралтгүй суралцах, улмаар өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийн чадавхийг бий болгох бодлого, стратегийн шийдлийг танилцуулсан.

Багш нарын улсын анхдугаар зөвөлгөөнд [3;6] Цэцэрлэгийн багш нар, ЕБС, Их дээд сургуулийн багш нараас ялгарах, хөдөлмөрийн онцлогтой тул тусгайлан хууль боловсруулах шаардлагатай байгааг олон багш санал болгож байлаа. Энэ асуудал биелэлээ олж СӨБ-н тухай хуультай болсон гэжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль [14;25] (2008.05.23)-н 5.12.4-т заахдаа: Багшийн заах арга, мэргэжлийн ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтыг төвлөрсөн, бүсчилсэн болон зайны хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан байгууллага мэргэжил арга зүйн удирдлагаар хангана гэж заасан байна. Мөн Багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт [2007.10.06. Дугаар 354-т] багшийн хөгжлийг хангах талаар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багшийн хөгжлийг хангах талаар

- Судалгаа шинжилгээний ажил хийх
- Илтгэл, ном, гарын авлага, зөвлөмж боловсруулах
- Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах, бусад багш нарт зориулан сургалт семинар зохион байгуулах
- Мэргэжил арга зүйгээ ажлын байран дээрээ тасралтгүй дээшлүүлэх гэж заажээ.


Хоёрдугаар бүлэг. Сургуулийн өмнөх бодловсролын багш ажлын байрандаа тасралтгүй хөгжиж байгааг судалсан нь

2.1 Судалгаа авсан арга зүй

Багш ажлын байрандаа тасралтгүй хэрхэн хөгжиж байгааг ажлын байранд нь очиж бичгээр, online хэлбэрээр гэсэн хоёр өөр аргаар авч харьцуулсан судалгаа гаргаж үзлээ.

1. Багш таньд ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх боломж байдаг уу?


Диаграмм №1



Диаграмм нэгээс харахад хоёр судалгаанд хамрагдсан багш нарын 80-90% нь ажлын байрандаа хөгжиж байна гэж үзжээ. Үлдсэн нь хувь нь зав чөлөө муу учраас өөрийгөө хөгжүүлэх боломжгүй байна гэсэн хариулт өгсөн.

2. Багш таньд өөрийгөө хөгжүүлэхэд хамгийн чухал нөлөө үзүүлдэг зүйлсийг нэрлэнэ үү?

Диаграмм №2



Диаграмм хоёроос харахад судалгаанд оролцсон нийт багш нар интернэт орчин, ном гарын авлага чухал нөлөөтэй гэж үзсэн байна. Хоёр судалгааг харьцуулахад бичгээр санал өгсөн багш нарт интернэт орчин илүү чухал болох нь харагдаж байна. Онлайн судалгаанд оролцсон багш нар дараа нь сургалтыг нэрлэсэн байна.

3. Таныг ажлын байран дээрээ хөгжихөд ямар бэрхшээл тулгардаг вэ?

Диаграмм №3



Диаграмм гураваас харахад судалгаа өгсөн нийт багш нарын дийлэнх нь ажлын ачаалал их, цаг зав бага байдаг нь өөрийгөө хөгжүүлэхэд сөрөгөөр нөлөөлдөг гэсэн байна. Үүнээс үзэхэд багш нар өөрийгөө хөгжүүлэхэд тулгамдаад байгаа хамгийн том бэрхшээл нь ажлын ачаалал болох нь ажиглагдаж байна.

4. Та ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэхийн тулд юу хийдэг вэ? Диаграмм №4



Диаграмм дөрөвөөс харахад судалгаа өгсөн багш нарын дийлэнх нь интернэт орчинг ашиглаж, ном гарын авлага уншиж өөрийгөө хөгжүүлдэг гэсэн байна. Хоёр судалгааг харьцуулахад бичгээр санал өгсөн багш нар өөрийгөө хөгжүүлэх нэлээн олон хувилбарыг нэрлэсэн байна.

5. Та ажлын байран дээрээ хөгжихөд байгууллагын зүгээс ямар дэмжлэг үзүүлдэг вэ?


Диаграмм №5



Диаграмм таваас харахад асуултанд дийлэнх саналыг сургалтанд суулгадаг, техник хэрэгсэл ном гарын авлагаар хангадаг гэсэн байна. Хоёр судалгааг харьцуулахад бичгээр санал өгсөн багш нар гадаад багш нартай туршлага солилцуулдаг гэж хариулсан бол онлайнаар санал өгсөн багш нар уралдаан тэмцээн зохион байгуулдаг гэж хариулсан байна.

6. Ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэхийн тулд

Диаграмм №6



Диаграмм зургаагаас харахад ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэхэд бичгээр судалгаа өгсөн багш нар 100% багаар ажилахыг илүүд үзсэн бол онлайнаар судалгаа өгсөн багш нарын 85% нь багаар ажиллахыг, 15% нь ганцаарчлан ажиллахыг илүүд үзжээ.

7. Таныг ажлын байран дээрээ хөгжихийн тулд байгууллагын зүгээс ямар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна вэ?


Диаграмм №7



Байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх нь багшийн хөгжилд маш чухал нөлөөтэй нь дээрх диаграммаас харагдаж байна. Мөн хүүхдийн тоо цөөлөх, ачаалал багасгах гэж хариулсан.

8. Та ажиллах явцдаа ажлын байран дээрээ ямар чиглэлээр хэдэн удаа өөрийгөө хөгжүүлсэн бэ?

Диаграмм №8



Диаграмм наймаас үзэхэд гадаад орнуудад туршлага судалсан гэж бичгээр судалгаа өгсөн багш нар 63% хариулсан бол онлайнаар судалгаа өгсөн багш нарын 34% нь туршлага солилцдог гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон нийт багш нар мэргэжлийн чиглэлээр сургалтан жилдээ 1-3 удаа суудаг гэж хариулсан байна.

Харьцуулсан судалгааны дүгнэлт

Судалгааг:

- Бичгээр
- Онлайнаар гэсэн хэлбэрээр авч харьцуулсан дүгнэлт гаргалаа.

Бичгээр ба онлайнаар судалгаа өгсөн багш нарын хувьд ажлын орчин нөхцөл, хамтран ажиллагсад нь өөр өөр учраас тодорхой зүйлүүд дээр ялгаа гарч байгаа нь ажиглагдсан.

Бичгээр судалгаа өгсөн багш нарын олонх нь интернэт орчинг ашиглаж, баг хамт олноороо хамтарч ажиллахыг илүүд үзсэн бол онлайнаар судалгаа өгсөн багш нарын олонх нь бусадтай туршлага солилцохдоо интернэт орчинг ашигладаг гэсэн байна.

Багш нарын хөгжих боломжийг байгууллага бүр олон талаас хангаж өгдөг нь дээрх хоёр судалгаанаас ажиглагдаж байна. Бичгээр судалгаа өгсөн багш нарын дийлэнх нь багаар ажиллах нь үр дүнтэй гэж үзсэн бол онлайнаар судалгаа өгсөн багш нарын цөөн хувь нь ганцаараа ажиллах нь үр дүнтэй гэж үзсэн.

Өөрийгөө хөгжүүлэхийг дийлэнх нь эрмэлздэг боловч ажлын нөхцөл байдал, ачаалал, ар гэрийн амьдралаас болж тодорхой бэрхшээл тулгарч байна. Үүнд:

- Ажлын ачаалал их
- Техник, тоног төхөөрөмж хангалтгүй
- Интернэтийн орчин байхгүй
- Ар гэрийн болоцоо муу гэх мэт

Бичгээр судалгаа өгсөн багш нарын ихэнх нь гадаадын туршлагаас судалж, боловсролын зэрэг ахиулж, интернэт орчноос мэдээ мэдээлэл авч, мэргэжлийн сургалтанд сууж, ажиллах хугацаандаа өөрийгөө хөгжүүлдэг гэсэн бол онлайнаар судалгаа өгсөн багш нарын ихэнх нь интернэт орчноос мэдээлэл авч, мэргэжилийн чиглэлээр жилд 3-4 удаа сургалтанд сууж, бусадтай туршлага солилцож өөрийгөө хөгжүүлдэг гэсэн байна.

Судалгааны ажлын ерөнхий дүгнэлт

Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд байгууллага бүр “Багшийн хөгжил” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж байна. Иймээс цэцэрлэгийн багш ажлын байранд хөгжиж байна.

Дараах зүйлүүдэд анхаарал хандуулах нь зүйтэй.

- Тасралтгүй арван цаг ажилладаг нөхцлийг өөрчлөх
- Техник технологийн дэвшлийг ашиглах, суралцах боломжоор хангах
- Гадаад дотоодын мэргэжил нэгт багш нартай уялдаа холбоотой ажиллаж, харилцан суралцах боломж бүрдүүлэх
- Урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон шинэчлэх
- Их, дээд сургуулийн эрдэмтэн багш нартай хамтын ажиллагаатай ажиллах
- Багшийн хөгжилд байгууллага, хамт олон, хувь хүмүүс, эцэг эхийг татан оролцуулах зэрэг ажлыг хийх шаардлагатай байна.

Багш бид:

- Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний биелэлт, үр дүнд анхааран ажиллах
- Багшийн төлөвлөгөөнөөс салбарлан хамт олноороо тасралтгүй хөгжих хэтийн төлөвлөгөө зохиох
- Бие дааж өөрийгөө хөгжүүлэх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай.

Ажлын байранд тасралтгүй хөгжих гол арга зам бол багш өөрийнхөө үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хийсэн бүтээсэн зүйлийнхээ тооноос илүү чанарт анхаардаг байх хэрэгтэй гэж үзэж байна.

Ном зүй

1. Батхуяг С, Ичинхорлоо Ш, Энхжаргал С, “Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс” УБ.,2006
2. Батзориг Ж, Саранчимэг Д, “Бидний лавлах” УБ.,2009
3. Боловсрол мэдээлэл сэтгүүл №6 УБ.,2007
4. Боловсрол мэдээлэл сэтгүүл №2, 4 УБ.,2008
5. Багш та хүүхдийн хөгжлийн хөтөч УБ.,2013
6. Багшийн хөгжил түүнийг үнэлэн дэмжих асуудлууд УБ.,2007
7. Жадамба Б, Батсуурь Ц, Пүрэв-Очир Б, Пүрэвдорж Д, “Багш боловсролын ирээдүй” УБ.,2005
8. Ичинхорлоо Ш, “Багшийн ном” УБ.,2004
9. Монгол улсын ЗГ, Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө УБ.,2007
10. Оюун Ц, Түмэндэмбэрэл Д, “Багшийн хөгжил” УБ.,2005
11. Оюун Ц, “Багшийн хөгжлийн арга зүйн зарим асуудал” УБ.,2003
12. Хүүхэд нэг бүрийн хөгжлийн төлөө УБ.,2013
13. Чанартай боловсрол хөгжлийн баталгаа УБ.,2001
14. СӨБ-ын хууль
15. Байгалмаа Ч, “Багш мэргэжлийн хөгжил туршилт судалгаа” УБ.,2013

